



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 8/44

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалтууд, ОХУ-ын Эрхүү хот дахь Сибирь, Алс дорнодын тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний хүрээлэн болон Монгол Улсын Эрүүл мэндийн яамны харьяа Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн хооронд байгуулсан гэрээ, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Баян-өлгий аймгийн Улаанхус, Ногооннуур, Цагааннуур сумдын хил орчмын нутагт тарваган тахал өвчний тандалт судалгаа"-ны ажлыг удирдамжийн дагуу чанартай гүйцэтгэж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны Биологич (С.Мөнгөнбагана)-д үүрэг болгосугай.
2. Байгалийн голомтын хамтарсан тандалт судалгааны зардал болох 4,232,000 (дөрвөн сая хоёр зуун гучин хоёр мянган) төгрөгийг томилолт, тээвэр шатахуун, эмийн зардлаас тооцож гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.
3. Хамтарсан тандалт судалгаанд ажиллах мэргэжилтнийг томилж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга (Л.Роломжав)-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (Г.Дашдаваа)-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЦОГБАДРАХ



1913100115

Disk E/2023/Zakhiriin tushaal A